



ӨВӨРХАНГАЙ АЙМГИЙН
БАТ-ӨЛЗИЙ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 12 сарын 12 өдөр

Дугаар А/951

Бат-Өлзий сум

Засаг даргын зөвлөлийг шинэчлэн
байгуулах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, сумын Засаг даргын зөвлөлийн 2024 оны 11 дүгээр сарын 29-ний өдрийн 13 дугаар хурлын тэмдэглэлийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Засаг даргын зөвлөлийг дараах бүрэлдэхүүнтэй шинэчлэн байгуулсугай.

Зөвлөлийн дарга: Засаг дарга

Гишүүд: Засаг даргын орлогч

Засаг даргын Тамгын газрын дарга

Багийн Засаг дарга нар

1 дүгээр сургуулийн захирал

2 дугаар сургуулийн захирал

Эрүүл мэндийн төвийн дарга

1 дүгээр цэцэрлэгийн эрхлэгч

2 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

3 дугаар цэцэрлэгийн эрхлэгч

Соёлын төвийн дарга

Цагдаагийн тасгийн дарга

Ойн ангийн дарга

Цахилгаан шугам сүлжээний салбарын эрхлэгч

Санхүү албаны дарга

Зөвлөлийн нарийн бичгийн дарга: Хууль эрх зүй хариуцсан мэргэжилтэн

2.Засаг даргын зөвлөлийн хурлыг цаг тухайд нь зохион байгуулж, цаг үеийн асуудлыг шийдвэрлүүлж ажиллахыг Зөвлөлийн нарийн бичгийн даргад үүрэг болгосугай.

3.Энэ захирамж гарсантай холбогдуулан “Засаг даргын зөвлөлийг шинэчлэн байгуулах тухай” сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 02-ны өдрийн А/11 дүгээр захирамжийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА  Н.ОРХОНТУУЛ

D:My Doc A-4 zahiramj /Zasag darga/

822301431